



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/178/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Хэлтсийн дарга бөгөөд

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424, 99442140

Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19

*Навсгалт:*



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ТАТВАРЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА С.РЭНЦЭНДАГВА  
ТАНАА

2021. 02. 15 № 2/28

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

2021 А4 ТООТ

005020889



хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,827,450.18</b>	<b>78,379,334.14</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>17,827,450.18</b>	<b>78,379,334.14</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>17,827,450.18</b>	<b>78,379,334.14</b>
35410	Бичиг хэргийн материал	4,314,684.18	3,149,221.00
35420	Аж ахуйн материал	9,782,600.00	21,752,507.46
35440	Түлш, шатах тослох материал	129,100.00	3,525.08
35450	Барилгын засварын материал	0.00	380,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,601,066.00	53,094,080.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>238,437,406.90</b>	<b>461,385,483.23</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>238,437,406.90</b>	<b>461,385,483.23</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>195,062,406.90</b>	<b>418,010,483.23</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	103,822,850.00	103,822,850.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10,640,133.25	-21,280,266.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,990,000.00	108,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,244,069.49	-45,428,975.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,434,940.00	248,034,528.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-66,110,389.92	-24,081,975.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,493,831.00	66,817,135.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,684,621.44	-18,862,812.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,780,000.00	3,780,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,780,000.00	-3,780,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>43,375,000.00</b>	<b>43,375,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	43,375,000.00	43,375,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>256,264,857.08</b>	<b>539,764,817.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>537,240.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>537,240.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>537,240.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>537,240.00</b>
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	0.00	537,240.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>256,264,857.08</b>	<b>539,227,577.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>256,264,857.08</b>	<b>539,227,577.37</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	268,961,050.75	268,961,050.75
51101	Өмч: - төрийн	268,961,050.75	268,961,050.75
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>148,146,930.24</b>	<b>134,815,790.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-88,861,871.27	148,146,930.24
51220	Тайлант үеийн үр дүн	-59,285,058.97	282,962,720.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,450,736.57	135,450,736.57
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>256,264,857.08</b>	<b>539,764,817.37</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>750,743,527.00</b>	<b>1,185,381,294.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,207,200.00</b>	<b>306,024,494.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,207,200.00</b>	<b>306,024,494.95</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,175,400.00	306,024,494.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,175,400.00	306,024,494.95
120009	Бусад орлого	31,800.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>746,536,327.00</b>	<b>879,356,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>714,340,200.00</b>	<b>848,356,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714,340,200.00	848,356,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,000,000.00	31,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>196,127.00</b>	<b>0.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	196,127.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>810,005,910.96</b>	<b>902,418,574.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>758,777,022.64</b>	<b>902,418,574.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>720,160,056.64</b>	<b>865,168,128.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>496,284,536.00</b>	<b>598,539,069.00</b>
210101	Үндсэн цалин	470,368,927.00	418,752,509.00
210102	Нэмэгдэл	11,192,263.00	95,449,551.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,223,346.00	17,697,109.00
210104	Урамшуулал	1,500,000.00	66,639,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,247,702.00</b>	<b>73,942,228.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,093,095.00	52,813,373.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,834,455.00	5,675,842.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,867,575.00	4,926,505.00
210204	Ажилгүйдлийн даатгал	950,217.00	1,180,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,502,360.00	9,345,908.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,830,867.00</b>	<b>46,366,593.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,347,677.00	3,112,799.00
210302	Түлш, халаалт	23,134,950.00	38,637,998.00
210303	Цэвэр, бохир ус	3,348,240.00	4,615,796.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,347,080.00</b>	<b>31,919,090.85</b>
210401	Бичиг хэрэг	7,170,910.00	7,075,391.18
210402	Тээвэр, шатахуун	9,320,900.00	5,389,574.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,535,142.00	5,287,638.00
210404	Ном, хэвлэл	128,000.00	267,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	530,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,662,128.00	13,458,886.75
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,572,450.00</b>	<b>1,619,690.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,432,250.00	0.00
210604	Урсгал засвар	11,140,200.00	1,619,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,997,500.00</b>	<b>5,072,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,997,500.00	5,072,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,244,750.02</b>	<b>63,705,640.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,670,000.00	63,008,240.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,834.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223,900.00	223,900.00

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	173,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,101,016.02	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,635,171.62</b>	<b>44,003,317.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,063,627.00	5,549,766.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,702,000.00	605,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,869,544.62	37,848,551.81
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>15,361.00</b>	<b>0.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>15,361.00</b>	<b>0.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	15,361.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,601,605.00</b>	<b>37,250,446.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,601,605.00</b>	<b>27,188,761.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,952,905.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,668,700.00	27,188,761.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,000.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>10,061,685.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	10,061,685.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>51,228,888.32</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>51,228,888.32</b>	<b>0.00</b>
220001	Барилга байгууламж	51,228,888.32	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-59,262,383.96</b>	<b>282,962,720.29</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>22,675.01</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,675.01	0.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-22,675.01</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-59,285,058.97</b>	<b>282,962,720.29</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>746,568,127.00</b>	<b>879,356,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,800.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>31,800.00</b>	<b>0.00</b>
120009	Бусад орлого	31,800.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>746,536,327.00</b>	<b>879,356,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>714,340,200.00</b>	<b>848,356,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714,340,200.00	848,356,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө байгууллага/	32,000,000.00	31,000,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>196,127.00</b>	<b>0.00</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,127.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>746,568,127.00</b>	<b>868,411,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>746,568,127.00</b>	<b>868,411,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>707,431,161.00</b>	<b>831,161,354.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>493,580,938.00</b>	<b>598,539,069.00</b>
210101	Үндсэн цалин	341,782,900.00	404,296,706.00
210102	Нэмэгдэл	71,815,946.00	105,473,561.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,799,000.00	19,279,609.00
210104	Урамшуулал	63,183,092.00	69,489,193.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,951,300.00</b>	<b>73,942,228.00</b>



210201	Тэтгэврийн даатгал	42,415,300.00	52,918,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,134,000.00	5,902,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,107,200.00	5,058,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,800.00	1,180,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,268,000.00	8,881,752.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,830,867.00</b>	<b>46,366,593.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,347,677.00	3,112,799.00
210302	Түлш, халаалт	23,134,950.00	38,637,998.00
210303	Цэвэр, бохир ус	3,348,240.00	4,615,796.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,897,795.00</b>	<b>26,678,874.00</b>
210401	Бичиг хэрэг	5,879,795.00	3,578,920.00
210402	Тээвэр, шатахуун	5,200,000.00	5,259,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,611,672.00	5,295,638.00
210404	Ном, хэвлэл	293,000.00	447,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	530,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,383,328.00	11,657,716.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,793,900.00</b>	<b>4,694,690.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	392,200.00	2,975,000.00
210604	Урсгал засвар	11,401,700.00	1,719,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,997,500.00</b>	<b>5,072,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,997,500.00	5,072,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>71,382,734.00</b>	<b>68,303,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,909,000.00	67,606,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,834.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223,900.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	223,900.00
210807	Газрын төлбөр	0.00	173,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,996,127.00</b>	<b>7,564,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	196,127.00	2,351,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,800,000.00	5,213,000.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>15,361.00</b>	<b>0.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>15,361.00</b>	<b>0.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	15,361.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,121,605.00</b>	<b>37,250,446.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,121,605.00</b>	<b>27,188,761.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,952,905.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,668,700.00	27,188,761.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>10,061,685.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	10,061,685.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>10,945,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>10,945,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>10,945,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>10,945,000.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	0.00	10,945,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-10,945,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	-88,861,871.27	0.00	315,549,916.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	-88,861,871.27	0.00	315,549,916.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-59,285,058.97	0.00	-59,285,058.97
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	-148,146,930.24	0.00	256,264,857.08
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	-148,146,930.24	0.00	256,264,857.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	-148,146,930.24	0.00	256,264,857.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	282,962,720.29	0.00	282,962,720.29
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	134,815,790.05	0.00	539,227,577.37



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	848,356,800.00	838,295,115.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	848,356,800.00	838,295,115.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	821,168,000.00	811,106,354.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	606,495,100.00	598,539,069.00
210101	Үндсэн цалин	419,942,800.00	404,296,706.00
210102	Нэмэгдэл	109,813,100.00	105,473,561.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,424,000.00	19,273,609.00
210104	Урамшуулал	59,315,200.00	69,489,193.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	75,811,900.00	73,942,228.00
210201	Тэтгэврийн даатгал	52,200,500.00	52,918,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,902,800.00	5,902,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,722,300.00	5,058,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,180,600.00	1,180,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,805,700.00	8,881,752.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,435,000.00	46,366,593.00
210301	Гэрэл, цахилгаан	3,113,000.00	3,112,799.00
210302	Түлш, халаалт	38,638,000.00	38,637,998.00
210303	Цэвэр, бохир ус	4,684,000.00	4,615,796.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,716,100.00	26,678,874.00
210401	Бичиг хэрэг	3,579,900.00	3,578,920.00
210402	Тээвэр, шатахуун	5,259,000.00	5,259,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,296,500.00	5,295,638.00
210404	Ном, хэвлэл	447,600.00	447,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	474,100.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,659,000.00	11,657,716.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,720,100.00	6,719,690.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	1,720,100.00	1,719,690.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	5,078,000.00	5,072,500.00
210702	Дотоод албан томилолт	0.00	5,072,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,078,000.00	0.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,427,800.00	37,303,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,606,000.00	36,606,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,400.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	223,900.00	223,900.00
210807	Газрын төлбөр	173,500.00	173,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,484,000.00	16,484,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,960,000.00	8,960,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,524,000.00	7,524,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,188,800.00	27,188,761.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,188,800.00	27,188,761.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,188,800.00	27,188,761.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	848,356,800.00	838,295,115.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	848,356,800.00	838,295,115.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	848,356,800.00	838,295,115.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	43	44
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	40	41
620003	Үйлчлэх ажилтан	2	2

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧЛӨГӨЙ  
САНАЛ ДЭГНЭЭТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,000,000.00	31,000,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>32,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,000,000.00	31,000,000.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч, С.Рэнцэндагва танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд харилцагч байгууллагуудтай хийх төлбөрийн баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ноос 2021 оны 01 дугаар сарын 28-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 сарын 27-ны өдрийн 319 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Татварын ерөнхий хуулийн 22 дүгээр зүйл. 22.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Татварын ерөнхий хуулийн 22.1.2.татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 22.1.3.улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Татварын ерөнхий газраас 2021 онд Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Татварын ерөнхий газраас 2021 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар тус Татварын хэлтэст шилэн дансны мэдээлэл шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 902418,6 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 18048,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг багасгах шаардлага гараагүй.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 283500,0 мянган төгрөгөөр буюу 106 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	17,827.5	78,379.3	60,551.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	17,827.5	78,379.3	60,551.9
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	238,437.4	461,385.5	222,948.1
Үндсэн хөрөнгө	373,896.6	574,819.5	200,922.9
Хуримтлагдсан элэгдэл	(135,459.2)	(113,434.0)	22,025.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>256,264.9</b>	<b>539,764.8</b>	<b>283,500.0</b>
Өр төлбөр	-	537.2	537.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	256,264.9	539,227.6	282,962.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>256,264.9</b>	<b>539,764.8</b>	<b>283,500.0</b>

Тухайн байгууллага нь өмнөх болон тайлант онд авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78379,3 мянган төгрөг болж өмнөх оноос 60551,9 мянган төгрөгөөр өссөн нь Шинэ байранд орсонтой холбоотой Татварын ерөнхий газраас үнэ төлбөргүй 37352,3 мянган төгрөгийн хөрөнгө, хамт олны хандиваар 13907,2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны өмнөх оны үлдэгдэл 373896,6 мянган төгрөг байсан бол тайлант оны эцэст 574819,5 мянган төгрөг болж цэвэр дүнгээр 200922,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба нийт хөрөнгийн орлого 260796,6 мянга нэмэгдэж 59873,7 мянган төгрөг акталсан байна. Тухайн Татварын хэлтэс нь шинэ байранд орсонтой холбоотой орон нутгаас 29701,0 мянга, Татварын ерөнхий газраас Азийн хөгжлийн



банкны санхүүжилтээр 89376,7 мянга, мөн Татварын ерөнхий газраас 14745,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах эрх шилжүүлсний дагуу харьцуулалтын аргаар хөрөнгө худалдан авсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны өмнөх оны үлдэгдэл 135450.7 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд тухайн дансанд өөрчлөлт гараагүй байна.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх онд 750743.5 мянган төгрөг байсан бол тайлант онд 1185381.3 мянган төгрөг болж 434637.8 мянган төгрөгөөр буюу 57.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь 714340.2 мянган төгрөгөөс 848356.8 мянган төгрөг болж 134016.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх онд 810005.9 мянган төгрөг байсан бол тайлант онд 902418,6 мянган төгрөг болж 92412,7 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн байна.

Энэ нь тайлант хугацаанд цалингийн зардал өмнөх ондоо 102254.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Цалингийн зардал өссөн нь Сангийн сайдын 2020 оны 168 тоот тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам” батлагдаж олгож эхэлсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3107916.2 мянган төгрөгөөр санал хүргүүлснээс шинэ барилгын хөрөнгө оруулалтын зардалд 2140040,0 тоног төхөөрөмжийн зардалд 6310,0 мянган төгрөг харин урсгал санхүүжилтэд 961566,3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 113209,5 мянган төгрөгөөр бууруулж 848356,8 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүргүүлсэн саналаас гол буурч батлагдсан зардал нь цалингийн зардал 73288,6 мянган төгрөгөөр ЭМНДШ 15958,8 мянга, тавилга авах зардалд 56420,0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 848356,8 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 848356,8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 838295,1 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 10061,7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 838295,1 мянган төгрөг буюу 98,8 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 7956,0 мянга, ажил олгогчоос олгох ЭМДШ-ийн зардлыг 1869,7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ХӨТӨЛБӨР 70205</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 80101</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>848,356,800.00</b>	<b>838,295,115.00</b>	<b>10,061,685.00</b>	<b>98.81</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>848,356,800.00</b>	<b>838,295,115.00</b>	<b>10,061,685.00</b>	<b>98.81</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>848,356,800.00</b>	<b>838,295,115.00</b>	<b>10,061,685.00</b>	<b>98.81</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	606,495,100.00	598,539,069.00	7,956,031.00	<b>98.69</b>
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,811,900.00	73,942,228.00	1,869,672.00	<b>97.53</b>
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,435,000.00	46,366,593.00	68,407.00	<b>99.85</b>
Хангамж, бараа материалын зардал	26,716,100.00	26,678,874.00	37,226.00	<b>99.86</b>
Нормативт зардал			0.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	6,720,100.00	6,719,690.00	410.00	<b>99.99</b>
Томилолт, зочны зардал	5,078,000.00	5,072,500.00	5,500.00	<b>99.89</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	821,800.00	697,400.00	124,400.00	<b>84.86</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	16,484,000.00	16,484,000.00	0.00	<b>100.00</b>
<b>ХӨТӨЛБӨР 70205</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 80205</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>486,000.00</b>	<b>486,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>486,000.00</b>	<b>486,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>486,000.00</b>	<b>486,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	486,000.00	486,000.00	0.00	<b>100.00</b>
<b>ХӨТӨЛБӨР 70205</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 80219</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,600,000.00</b>	<b>21,600,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,600,000.00</b>	<b>21,600,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,600,000.00</b>	<b>21,600,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600,000.00	21,600,000.00	0.00	<b>100.00</b>
<b>ХӨТӨЛБӨР 70205</b>			0.00	
<b>АРГА ХЭМЖЭЭ 80220</b>			0.00	
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>14,520,000.00</b>	<b>14,520,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,520,000.00</b>	<b>14,520,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,520,000.00</b>	<b>14,520,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,520,000.00	14,520,000.00	0.00	<b>100.00</b>
<b>ХӨТӨЛБӨР 70205</b>			0.00	
<b>АРГА ХЭМЖЭЭ 80802</b>			0.00	
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,188,800.00</b>	<b>27,188,761.00</b>	<b>39.00</b>	<b>100.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,188,800.00</b>	<b>27,188,761.00</b>	<b>39.00</b>	<b>100.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,188,800.00	27,188,761.00	39.00	<b>100.00</b>

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 15000,0 мянган төгрөгийн орон сууцны хөнгөлөлт орж ирснийг 3 албан хаагчид тус бүр 5000,0 мянган төгрөг өгч, 8000,0 мянган төгрөгийн аймгийн Засаг даргын үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардал орж ирснийг Татвар төлөгчдийн өдрөөс татварын хууль тогтоомж сурталчлах зорилгоор тарааж өгөх материал, самбар хийлгэсэн, мөн аймгийн хэлтэс агентлагуудын дунд зарласан уралдааны хүрээнд тэргүүн байрт орж 8000,0 мянган төгрөгөөр шагнуулсныг хамт олноор хэлэлцэж шинэ байрны тохижилтод зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл байгаа бол хандивын зарцуулалтын тайланг жилээр мэдээлэх байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	9	0	1
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	95	1	0
6	Нийт	27	151	148	1	1

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5042,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 537,2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 194,0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад арилгаж 4311,0 төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар цалинг давтан тооцоолоход 2020 оны 12 дугаар сард 537,2 мянган төгрөгийн ЭМНДШ-ийн өглөг дутуу тусгасан байсныг залруулах бичилт хийв.

Шийдвэрлэсэн нь:



## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 194,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд аудитын явцад зөрчлийг арилгав. Үүнд:

1. Цалинг давтан тооцоолоход Ажиллагсдад олгосон урьдчилгаа цалингаас 50,0 мянган төгрөгийн урьдчилгааг дутуу суутгасан байхад авлагаар тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, УСНББОУС 15 стандартын С15-д зааснаар САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРТ: “авлага” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад зөрчил арилгасан.

2. 10 дугаар сард гэрээт ажилтны 600,0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалд мэдээлээгүй, 144,0 мянган төгрөгийн шимтгэл төлөгдөөгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т заасан “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалттай нийцэхгүй эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад зөрчил арилгасан.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4311,0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

##### **1.1. Илрүүлэлт:**

Хичээл практикийн зардлаас 4311,0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.

##### **1.2. Эрсдэл:**

Үргүй зардал гарах

##### **1.3. Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг зогсоож, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах.

##### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Байхгүй

#### **2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ**

##### **2.1. Илрүүлэлт:**

Нийт 150 мэдээ мэдээлэхээс 148 мэдээг хугацаанд нь байршуулж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) мэдээлэх 1 мэдээг хоцроож, Хандив, тусламжийн хэмжээ,

түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр,Хагас жилээр)-г бүтэн жилээр мэдээлээгүй байна.

2.2. Эрсдэл:

Шилэн дансны хууль тогтоомж зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1-д заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх. 2020 оны хандив тусламжийн зарцуулалтын тайланг нөхөн мэдээлэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Байхгүй

3. **ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**

3.1. Илрүүлэлт:

Ахмадын санд 6500,0 мянган төгрөг зарцуулахдаа төрийн бус байгууллагаар дамжуулан зарцуулсан.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Ахмадын санд хөрөнгө зарцуулахдаа Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ын 1.4-т заасан “Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хариуцан гүйцэтгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Б.АЗБАЯР 2021.02.15

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2021.02.15

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2021.02.15



*Ховсралт*  
**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020 он			БНА-2021/154/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Баянхонгор аймгийн Татварын хэлтэс</b>		Мянган төгрөг:

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалинг давтан тооцоолоход 537,2 мянган төгрөгийн ЭМНДШ-ийн өглөг дутуу тусгасан.	537,2	Санхүүгийн тайланд залруулав.	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Рэнцэндагва, Д.Бат-Орших
2	Хичээл практикийн зардлаас 4311,0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.	4311,0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Рэнцэндагва, Д.Бат-Орших
<b>дүн</b>		<b>4848,2</b>			

- о о о -